



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 31 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Хөрөнгө актлах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, тус газрын Дүрмийн 2.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2011 оны 120 дугаар тогтоолын дагуу аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад олгох зөвшөөрлийн гэрчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын санал хүсэлтийн дагуу монгол, англи хэл дээр шинэчлэн хэвлүүлсэнтэй холбогдуулан монгол хэл дээр хэвлэгдсэн шаардлага хангахгүй 844 ширхэг гэрчилгээг актлахыг зөвшөөрсүгэй.

2. Хуучин гэрчилгээг журмын дагуу актлах ажлыг зохион байгуулахыг байгууллагын дэргэдэх Өмч хамгаалах зөвлөлийн дарга /Э.Мөнхзул/, ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/ нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БАТТУЛГА

1150590017